



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

Г Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа Г  
эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт  
оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мөнх даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,500,000,000.00 /нэг тэрбум таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Мөнх даатгал” ХХК /Т.Оюунгэрэл/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2018 оны .5 дугаар сарын 23-ны өдрийн  
133 дугаар тогтоолын хавсралт



“МӨНХ ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 20 000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 20 000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Т.Оюунгэрэл	85,080	1,701,600,000.00	48.63%	21,883	437,660,000.00		106,963	2,139,260,000.00	42.79%
2	Ч.Отгонжаргал	30,108	602,160,000.00	17.20%	7,740	154,800,000.00		37,848	756,960,000.00	15.14%
3	Д.Батжавхлан	28,100	562,000,000.00	16.05%	7,223	144,460,000.00		35,323	706,460,000.00	14.13%
4	Ч.Жигжид	15,856	317,120,000.00	9.06%	18,077	361,540,000.00		33,933	678,660,000.00	13.57%
5	Р.Нямсүрэн	15,856	317,120,000.00	9.06%	4,077	81,540,000.00		19,933	398,660,000.00	7.97%
6	Ж.Мөнхсүх				16,000	320,000,000.00		16,000	320,000,000.00	6.40%
	<b>Нийт</b>	<b>175,000</b>	<b>3,500,000,000.00</b>	<b>100%</b>	<b>75,000</b>	<b>1,500,000,000.00</b>		<b>250,000</b>	<b>5,000,000,000.00</b>	<b>100%</b>